



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/554

Мандалговь

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, 29.1.6 /г/, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 17 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монголын Эмнести интернэшнл, Отгон тэнгэр дээд сургуулиас хамтран зохион байгуулах "Эрхээ мэдье" Карл Попперын мэтгэлцээний улсын аварга шалгаруулах тэмцээнд аймгаа төлөөлөн оролцох "Эрдмийн далай" цогцолбор сургуулийн "Тэмүүлэл" багийн 3 сурагч, 1 багшийн замын зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. Замын зардлыг нэг хүнд 13000 (Арван гурван мянга) төгрөгөөр тооцож, ирэх, очих 2 талдаа 26000 (Хорин зургаан мянга) төгрөг, нийт 104.000 (Нэг зуун дөрвөн мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010698